

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.08.25-2017.09.25/

### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын ИТХ, ЗДТГ болон аж ахуй нэгж байгууллагуудын “Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг”-ийг 2017 оны 09-р сарын 13-ны өдөр сумын төв талбайд зохион байгуулж нийт 10 байгууллагын 68 албан хаагч оролцож, давхардсан тоогоор 1079 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлж, 1479 брошур, гарын авлага тарааж, 11 өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авснаас газар дээр нь 10 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Мөн ЗДТГ-ын албан хаагчдын хүнд суртал, цаг баримтлал, зан харилцааны талаар санал асуулга авахад сайн үнэлэгдсэн байна.



Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Эрдмийн баяр”-ыг угтан хагас, бүтэн өнчин болон нэн ядуу өрхийн 20, хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдэд 735000 төгрөгийн хичээлийн хэрэгсэл гардууллаа.



“Шивээ-Овоо” ХК-тай хамтран сумын амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн 1-5 дугаар ангийн 20 хүүхдэд 1,4 сая төгрөгийн сурагчийн дүрэмт хувцас гардууллаа.



Сумын Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах комисс өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэж буй өвөлжилтийн бэлтгэл ажлуудад 2 удаа хяналт шалгалт хийн ажиллаж байна. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 79,5 %-ийн гүйцэтгэлтэй байна.

### **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

Сумын Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/82 тоот Захирамжаар “Монгол Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн сургалт, хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулах ажлын хэсэг 17 хүний бүрэлдэхүүнтэй томилогдож сургалт, хэлэлцүүлгийг 3 үе шаттайгаар 4 удаа зохион байгуулж 158 иргэн хамрагдаж 254 иргэн саналын хуудсаар саналаа өгсөн байна.



Өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлтийн 3-р улирлын мэдээг гаргаж аймгийн төрийн захиргааны удирдлагын хэлтэст гаргаж хүргүүлсэн. Үүнд: 2017 оны 3-р улирлын байдлаар Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 51 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 568 нийт 619 өргөдөл хүлээн авсанаас 614 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.

## **ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ**

2017 оны 09-р сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	30031600	29782109
2.	ЗДТГ	190974073	187152012

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	Эрүүл мэндийн төв	220759500	218198925
2.	Соёлын төв	38011500	37633344
3.	3-р сургууль	601088300	557237379
4.	3-р цэцэрлэг	281789100	254417217

## **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ:**

### **3-Р АХЛАХ СУРГУУЛЬ**

Сургууль, цэцэрлэгийн 09 сарын 01-ний өдрийн 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд сумын удирдлагууд оролцлоо. Энэ жил нэгдүгээр ангид 91 хүүхэд элсэн орж 3 бүлэгт суралцаж байна.



### **3-Р ЦЭЦЭРЛЭГ**

Цэцэрлэгийн хүүхдийн бүртгэлийг 08 сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 346 хүүхэд бүртгүүлсэнээс бага бүлэгт шинээр 53 хүүхэд хамрагдлаа.

Цэцэрлэгийн бүх бүлгүүд эцэг эхийн хурал хийж хичээлийн шинэ жилийн зорилго, зорилт, цөм хөтөлбөрийн талаар ярилцан эцэг, эхчүүдтэй гурвалсан гэрээ байгууллаа.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

Эрүүл мэндийн төвд 53 өвчтөн хэвтэж үүнээс хүүхэд-22, дотор- 29, төрөх-2 хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

Дуудлага-88

Амбулаторийн үзлэгт-183 иргэн хамрагдсан байна.

3-р цэцэрлэгийн багш нарт хараа шалгах хараа хамгаалах чиглэлээр зөвлөгөө мэдээллийг өгч, цэцэрлэгийн хүүхдүүдэд Нүдээ хайрлаарай дуу, Нүдээ хамгаалах аргын талаар видео хичээл үзүүлэн ажиллалаа.

## **УЛСЫН БҮРТГЭЛ**

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 108 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 18 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2017 оны 9 сарын 22-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 5 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн 76 гэрчилгээг эздэд нь олгоод байна.

Иргэдээс 9 сард 83 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ  
БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

2017.09.21.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2017оны 9-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоолт	2500	8	20000				
2	Иргэний үнэмлэхний үнэ	15000	24	360000	3300	24	79200	
3	Гэрлэлтийн бүртгэл	2500	2	5000				
4	Өөр аймаг шилжин явсан	2500	4	10000	1000	4	4000	
5	Сум доторх шилжилт хөдөлгөөн	1500	6	9000	1000	6	6000	
<b>ДҮН</b>		<b>404000</b>			<b>89200</b>			
<b>НИЙТ ДҮН</b>		<b>493200</b>						

**ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2017 ОНЫ 09 САРЫН МЭДЭЭ**

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	59				59	37	22
Төрсөн эх	2	59				59	-	59
Бүртгүүлсэн гэр бүл	3	11				11	11	11
Нас баралт	4	13				13	9	4
Цуцалсан гэр бүл	5	4				4	4	4
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	94				94	45	49
Аймаг, нийслэлрүү шилжин явсан	8	76				76	35	41

## НИЙГМИЙН ХАЛАМЖ

Шинээр тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид хамрагдаж байгаа иргэдийн өргөдлийг холбогдох баримтын хамт хүлээн авч 7081020 төгрөгийн олголтыг хийлгэж ажилласан. Үүнд

1. Жирэмсэн нярай хөхүүл эхийн мөнгөн тэтгэмж – 14 иргэнд 668090 төгрөг
2. Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд сувилуулсан – 34 ахмад настанд 2230800 төгрөг
3. Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд сувилуулсан – 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 140000 төгрөг
4. Ахмадын зориулалттай амралтанд амарсан – 5 ахмад настанд төгрөг 1000000 төгрөг
5. Хиймэл шүд хийлгэсэн – 2 ахмад настан 240000 төгрөг
6. Нүдний уян болор суулгуулсан – 1 ахмад настанд 460000 төгрөг
7. Сонсголын аппарат суулгуулсан – 2 иргэнд 1400000 төгрөг
8. Тэтгэвэрийн сунгалт хийлгэсэх – 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 446190 төгрөг
9. Ахмад настаны тэтгэвэрт – 1 ахмад настанд 266450 төгрөг
10. Асаргааны сунгалт 2 иргэн, шинээр 1 иргэн нийт – 3 иргэнд 229490 төгрөг

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 6 иргэний өргөдлийг шийдвэрлэн асаргааны мөнгөн тэтгэмжид – 3 иргэн, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид – 3 иргэнийг хамруулсан.

Доктор тун ХХК сумын 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 1 ахмад настанд нийт 2100000 төгрөгийг сонсголын аппарат суулган өгсөн.



Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сургалтаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, өрх толгойлсон эмэгтэй болон сумын зорилтот бүлгийн 25 иргэнд “Гэр бүлийн баяр хөөр”, “Өрхийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хуримтлал бий болгох” сэдэвт сургалтуудыг аймгийн “Шинэ хөгжлийн түлхүүр”

ТББ –тай хамтран 2017 оны 09-р сарын 20-24-ны өдрүүдэд зохион байгууллаа.

### **НИЙГМИЙН БОДЛОГО**

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд суманд дугуйлан секц хичээллүүлдэг байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор 3-р сургууль, “Хаялага” спорт клуб, Соёлын төвийн дэргэдэх “шивээн ганхаа” хамтлагтай хамтран 2017 оны 09 сарын 13-нд өдөрлөг зохион байгуулж дугуйлан секцийн танилцуулгыг иргэдэд танилцуулж, хамрагдах хүсэлтэй хүүхэд, залуусыг бүртгэж ажиллаа.

Ахмадын баярыг угтан “Ахмадаа хүндэлье” аяныг 2017 оны 09 дүгээр сарын 12-оос 10 дугаар сарын 01 хооронд зарлаж аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:



- “Хариу нэхээгүй тус” аян
- Байгууллага бүр Ахмадын зөвлөх багийг урьж, ярилцлага зохион байгуулах
- Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх баярын арга хэмжээ зохион байгуулах
- Сумын Ахмадын хороотой хамтран ахмадуудын дунд “Бид угийн бичгээ өвлүүлэн үлдээгчид” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

### **БАЙГАЛЬ ОРЧИН**

Сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг 09-р сарын 08-ний өдөр зохион байгуулж 19 аж ахуйн нэгж байгууллагын 125 иргэн хамрагдаж 8,9 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төв хогийн цэгт ачиж зайлуулсан.



## ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

“Намрын ногоон өдрүүд” аймгийн үзэсгэлэн худалдаанд сумаас 6 иргэн оролцож сумын ногоочин Т.Ганбаатар, Б.Аманбек нарын тарьж ургуулж буй “Хаялага тарвас” “Нутгийн брэнд бүтээгдэхүүн”-ээр шалгарлаа.



Сумын “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг 2017 оны 09-р сарын 13-ны өдөр зохион байгуулж 17 иргэн 7 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож нийт 1,924,000 төгрөгийн борлуулалт хийлээ. Уг үзэсгэлэн худалдааг 5 нэр төрлөөр шалгаруулалт явуулж төрөл тус бүрийн ялагчийг тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Мөн “Дэмбээ” тэмцээнийг зохион байгууллаа.



Сумын Засаг даргын 2017 оны 8 сарын А/83 дугаар захирамжийн дагуу мал угаалгын ажлыг зохион байгуулж 27 өрхийн 19195 толгой малыг угаалгад хамруулсан.

Хөдөө өрхүүдээр тойрч намрын хянан баталгаажуулалт, ээмэгжүүлэлтийн ажлыг аймгийн “Сүмбэр хишигтэн зоо” МҮН-тэй хамтран зохион байгуулж 17 өрхийн 1210 толгой малд намрын ангилалт хийж, ээмэгжүүлсэн.





Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт оторлож байгаа гадны аймаг, сумын малчин 6 өрхөд нүүлгэх албан шаардлага өгч мөн малчин өрхүүдэд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага тарааж ажиллаа.

Суманд хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүр, лангуунуудад 2017 оны 09 дүгээр сарын 06-ний өдөр хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгч ажиллаа.



Ургац хураалтын ажил 80%-тай явагдаж байна. 09-р сарын 25-ны өдрийн байдлаар сумын хэмжээнд нийт 54 тн хүнсний ногоо хурааж төмс, тарвас, өргөст хэмх, улаан лооль, амтат гуа зэрэг хүнсний ногоонуудыг зах зээлд нийлүүлж байна. Мөн сумын 2 иргэн 174 тонн хадлан хадсан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБХ, ХХААГ-тай хамтран сумын зоорь, агуулахын тооллогын ажлыг зохион байгууллаа. Сумын хэмжээнд махны 1 зоорь, ногооны 5 зоорь тоологдсон.

Дорноговь аймгийн “Жүд Жи Жигдэн” ариутгал, халдваргүйжүүлэлтийн компани 3-р сургууль, 3-р цэцэрлэг, худалдааны 5 төв, мах нядалгааны 1 цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийлээ.

Сумын төв талбайн урд түр худалдаа явуулах газрыг ИТХ-аар батлуулан түр худалдаа явуулах талбайг




тохижуулах ажлыг зохион байгуулан машины зогсоол, сүүдрэвч хийж байршууллаа.

### ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН


3, 8-р байранд хэрэглээний халуун усны шугам тавих ажлыг ОНХС-ийн 14,6 сая төгрөгийн хөрөнгөөр “Илч” иргэдийн бүлэг гүйцэтгэж 416м хэрэглээний халуун усны шугам татаж 2017 оны 09-р сарын 30-нд комисст хүлээлгэн өгсөн.




ОНХС-ийн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийг камержуулах ажлыг Говьсүмбэр аймгийн “Чойрын долгио” ХХК гүйцэтгэж сумын төвийн 6 цэгт 2 эргэдэг, 4 чиглэлийн камер суурилуулан комисст хүлээлгэн өглөө.



ОНХС-ийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр Илчлэг шивээ ОНӨҮГ-т бага оврын зуух авах, угсарч суурилуулах ажлыг Илчит сансар ХХК гүйцэтгэж 2017 оны 09-р сарын 08-нд комисст хүлээлгэн өглөө.



ОНХС-ийн 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр Илчлэг шивээ ОНӨҮГ-т 1500 квт-ын хүчин чадалтай ялтсан бойлер худалдан авч угсарч суурилуулах ажлыг Илчит сансар ХХК гүйцэтгэж комисст хүлээлгэн өглөө.



Сумын Засаг даргын 2017 оны 09-р сарын 19-ны өдрийн А/101 тоот захирамжаар нохой устгах арга хэмжээний шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон 2-р багийн иргэнтэй гэрээ байгуулан нохой устгах ажлыг зохион байгуулж 09-р сарын 25 –ны өдрийн байдлаар 52 нохой устгаад байна.

3-р сургуулийн сантехникийн засварын ажлыг 1-р багийн иргэн Г. Батсайхан хийж гүйцэтгэж комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.